

МОНГОЛБАНКНЫ ЦАХИМ ХУУДАС ЭРХЛЭХ ЖУРАМ

НЭГ. Журмын зорилго

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Монголбанкны цахим хуудсыг эрхлэх, хяналт тавих, шинэчлэх, мэдээ оруулах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Журмын нэр томъёо

- 2.1 Монголбанкны цахим хуудсаар түгээгдэх мэдээ, мэдээлэл гэдэгт Монгол Улсын “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуульд хамаарахаас бусад Монголбанктай холбоотой бүх төрлийн мэдээ, фото мэдээ, зар сурталчилгаа, статистик тоо мэдээллийг хэлнэ.
- 2.2 Вэб мастер гэдэгт цахим хуудасны программыг боловсруулах, ажиллуулах, засварлах, шинэчлэх үйл ажиллагааг хариуцсан ажилтанг хэлнэ.
- 2.3 Вэб администратор гэдэгт цахим хуудаст мэдээг тогтмол, цаг хугацаанд нь байршуулах болон байршиж буй эсэхэд хяналт тавих, цаг үеийн шуурхай мэдээ, мэдээллийг Англи хэл рүү хөрвүүлэх, олон нийтэд зориулсан статистик мэдээллийг боловсруулах, цахим хуудасны өдөр тутмын үйл ажиллагааг ханган ажиллаж буй ажилтанг хэлнэ.
- 2.4 Мэдээ оруулах эрх бүхий ажилтан гэдэгт мөнгөний бодлогын үйл ажиллагаатай холбоотой, түргэн давтамжтай өөрчлөгддөг мэдээ мэдээллийг (тухайлбал, ТБҮЦ, албан ханш г.м.) цахим хуудаст байршуулах эрх бүхий ажилтанг хэлнэ.

ГУРАВ. Нийтлэг зүйл

- 3.1 Монголбанкны цахим хуудас нь Монголбанкнаас олон нийтэд мэдээ, мэдээлэл түгээх хэрэгсэл байна.
- 3.2 Монголбанкны цахим хуудсын үйл ажиллагаа нь Монголбанкны вэб мастер, вэб администратор болон мэдээ оруулах эрх бүхий ажилтнаар дамжуулан мэдээ, мэдээлэл хүлээн авагчдын хүрээнд явагдана.
- 3.3 <http://www.mongolbank.mn> нь Монголбанкны цахим хуудасны албан ёсны хаяг байна.
- 3.4 Монголбанкны цахим хуудасны мэдээ, мэдээлэл түгээх хэл нь Монгол, Англи хэл байна. Цахим хуудасны Монгол, Англи хувилбар бүтэц агуулгын хувьд ялгаатай байж болно.

ДӨРӨВ. Зорилго, үйл ажиллагаа

- 4.1 Монголбанкны цахим хуудасны эрхэм зорилго нь Монголбанкны үндсэн зорилт болон үйл ажиллагаа, түүнтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд түргэн шуурхай, үнэн зөв хүргэх явдал юм.
- 4.2 Монголбанкны цахим хуудасны байнгын үйл ажиллагааг Монголбанкны Тамгын газрын Олон нийттэй харилцах хэлтэс /ОНХХ/ хөтлөн явуулна.
- 4.3 Монголбанкны цахим хуудасны үйл ажиллагаа тасралтгүй явагдах үндсэн зарчим нь мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэх, өөрчлөх; олон нийт цахим хуудсаар дамжуулан мэдээ мэдээлэл хүлээн авах явдал байна.
- 4.4 Монголбанкны удирдлага болон ажилтнууд нь цахим хуудасны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад мэдээллээр хангах буюу мэдээлэл оруулж оролцоно.

ТАВ. ОНХХ-ийн эрх, үүрэг

- 5.1 ОНХХ нь цахим хуудсын өдөр тутмын үйл ажиллагааг Монголбанкны удирдлага болон ажилтнуудын дэмжлэгээр түүний зорилго, чигт нийцүүлэн хөтлөнө.
- 5.2 ОНХХ нь цахим хуудасны үйл ажиллагаанд мөрдөх журмыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулж, түүнийгээ мөрдлөг болгон ажиллана.
- 5.3 ОНХХ нь цахим хуудсыг түүний зорилго, журамд нийцсэн байхаар бүрэн төлөөлөх, хариуцах онцгой эрхтэй.
- 5.4 ОНХХ нь цахим хуудасны зорилго, журамд нийцүүлэн байгууллага дотор бусад газар, хэлтэс, албадтай байнгын холбоотой ажиллаж, цахим хуудасны тасралтгүй үйл ажиллагааг хангахуйцаар зохицуулах үүрэгтэй.
- 5.5 ОНХХ нь цахим хуудастай холбоотой санал, шүүмж, зөвлөмжийг Монголбанкны газар, хэлтэс, алба, банк, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагаас авах үүрэгтэй.
- 5.6 ОНХХ нь цахим хуудасны бүтэц, агуулга, хэв загварыг тухайн үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн өөрчлөх эрхтэй.

ЗУРГАА. Цахим хуудаст мэдээ, мэдээлэл оруулах

- 6.1 Монголбанкны цахим хуудаст вэб администратор, вэб мастер болон мэдээ оруулах эрх бүхий ажилтан мэдээ, мэдээллийг оруулна.
- 6.2 Монголбанкны цахим хуудаст Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу нийтэд ил тод болгох мэдээ мэдээлэл заавал байршина.
- 6.3 Цахим хуудаст байх тогтмол мэдээ, мэдээллийг Монголбанкны холбогдох газар тухай бүр; графикт мэдээллийг газрууд батлагдсан хуваарийн дагуу /тухайлбал, Статистик мэдээлэл тархаах хуваарь/ ОНХХ-т ирүүлэх буюу оруулна.

- 6.4 Цахим хуудасны агуулга, хариуцах газар, алба болон мэдээллийн давтамжийг Хоёрдугаар хавсралтанд үзүүлэв.
- 6.5 Мэдээлэл оруулах эрх бүхий ажилтан цахим хуудаст мэдээллийг оруулахдаа тухайн газар, хэлтэс, албадын захирлуудын зөвшөөрлөөр мэдээллийг оруулна.
- 6.6 Вэб администратор Хоёрдугаар хавсралтанд тусгагдснаас бусад мэдээ, мэдээллийг зөвхөн газрын захирлын гарын үсэг бүхий “Цахим хуудсанд мэдээлэл байршуулах зөвшөөрөл”-ийн дагуу цахим хуудсанд байршуулна.

ДОЛОО. Бусад

- 7.1 Цахим хуудаст зөвхөн Монголбанк, түүний түнш байгууллагуудын /МИБ, МБЭС, SEACEN, BIS, IMF, WB, ADB г.м/ мэдээ мэдээлэл, холбоосуудыг байршуулна.
- 7.2 Цахим хуудасны мэдээний үнэн бодит эсэхийг энэ журмын Хоёрдугаар хавсралтад заасан хуваарийн дагуу хариуцсан газар, хэлтэс, албаны ажилтан, захирал нар давхар хяналт тавьж ажиллана.
- 7.3 Монголбанкны сервер, сүлжээ болон бусад холбогдох техникийн аюулгүй, шуурхай, найдвартай ажиллагааг Мэдээллийн Технологийн газар хариуцан ажиллана.
- 7.4 Цахим хуудаст аливаа буруу, ташаа мэдээлэл оруулсаны хариуцлагыг тухайн мэдээллийг оруулахыг зөвшөөрсөн ажилтан, албан тушаалтан хариуцна.
- 7.5 Монголбанкны ажилтан, албан тушаалтан энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 7.6 Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Монголбанкны дотоод журамд зааснаар зохицуулна.

_____оОо_____

*Монголбанкны Ерөнхийлөгчийн
2011 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн
361 дүгээр тушаалын Хоёрдугаар хавсралт*

ЦАХИМ ХУУДАСНЫ АГУУЛГА, ХАРИУЦАХ ГАЗАР БА ДАВТАМЖ

Д/д	Цэс	Агуулга	Хариуцах газар	Давтамж
1.	Бидний тухай	Монголбанкны тухай	ТГ	Жил бүр
		Монголбанкны эмблем		
		Захирлуудын зөвлөл		
		Монголбанкны бүтэц		
		Эрдэнэсийн сангийн музей	ВЭЗГ	
		Төв банкны тухай хууль	ХХ	
		МБ-ны Жилийн тайлан	ТГ	Тухай бүр
		МБ-ны ажилтны ёс зүйн дүрэм		
		Олон улсын хамтын ажиллагаа		
		Зар		
2.	Мөнгөн тэмдэгт	Цаасан дэвсгэрт	МБСГ	Тухай бүр
		Зоосон тэмдэгтүүд		
		Дурсгалын зоос	ВЭЗГ	
3.	Мөнгөний бодлого	Мөнгөний бодлогын үндсэн зорилт	МБСГ	Жил бүр
		Инфляцийн хүлээлтийн судалгаа		Улирал бүр
		Мөнгөний бодлогын үндсэн чиглэл		Жил бүр
		Бодлогын хүү		Жил бүр
		Бодлогын хэрэгслүүд		Тухай бүр
		ОУВС-тай хэргжүүлсэн хөтөлбөр		Тухай бүр
		ДБ-ны эдийн засгийн тойм	ТГ	Улирал бүр
		Дэлхийн санхүүгийн захын тойм	ЭУА	7 хоног бүр
		4.	Валютын дотоод зах	Албан ханш
Валютын дуудлага худалдаа	Тухай бүр			
Валютын форвард, своп хэлцэл				
5.	Төлбөрийн систем	Танилцуулга	ТТБГ	Тухай бүр
		Бодлого, стратеги		
		Төлбөр тооцооны үндэсний зөвлөл		
		Судалгаа/Тайлан		
6.	Санхүүгийн тогтвортой байдал	СТБ-ын тухай	ХШГ	Жилд 1 удаа
		СТБ-ын зөвлөл		
		Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх	СМА	
		СТБ-ын үзүүлэлтүүд	ХШГ	
		СТБ-ын судалгаа		
		СТБ-ын тайлан		Тухай бүр

Д/д	Цэс	Агуулга	Хариуцах газар	Давтамж
7.	Статистик	Сарын бюллетень	МБСГ	Сар бүр
		ХҮИ		Сар бүр
		Мөнгө, зээл		Сар бүр
		Төв банкны хүү		Тухай бүр
		Ханш	ВЭЗГ	Өдөр бүр
		Гадаад сектор		Сар, улирал, жил бүр
		ТБҮЦ	МБСГ	Тухай бүр
		Худалдан авсан алт	ВЭЗГ	Сар бүр
		Бусад	МБСГ	Тухай бүр
8.	Хууль, эрх зүйн акт	Төв банкны талаар	ХХ	Тухай бүр
		Хяналт, шалгалтын талаар		
		Мөнгөний бодлогын талаар		
		Валют зохицуулалтын талаар		
		Төлбөр тооцоо, бүртгэлийн талаар		
9.	Хэвлэмэл бүтээгдэхүүн	Сарын бюллетень	МБСГ	Сар бүр
		Жилийн тайлан		Жил бүр
		Судалгааны ажил		
		Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл		
10.	СМА	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх	СМА	Жил бүр
		СМА-ны танилцуулга		
		СМА-ны чиг үүрэг		
		ФАТФ-ын зөвлөмж		
		Сэжигтэй гүйлгээ		
		Холбогдох хууль, журам		
		Статистик		Тухай бүр
		Типологи		Жил бүр
		Холбоо барих		
11.	БСТ	Бидний тухай	БСТ	Жил бүр
		Сургалт		Тухай бүр
12.	Хяналтын зөвлөл	ХЗ-ийн гишүүд	ХЗ	Тухай бүр
		ХЗ-ийн журам		
		ХЗ-ийн санал, зөвлөмж		
13.	Хэвлэлийн төв	Хэвлэлийн мэдэгдэл	МБСГ	Тухай бүр
		Хэвлэлийн хурлын тов	ТГ, МБСГ	Жил бүр
		Ярилцлага, нийтлэл	ТГ	Тухай бүр
		Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам		
		Монголбанкны цахим хуудас		

Д/д	Цэс	Агуулга	Хариуцах газар	Давтамж
		эрхлэх журам		
		Фото сурвалжлага		
		Асуулт/Хариулт		
		Видеоролик		

_____оОо_____